



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/14

Мөрөн сум

Хандив тусламж бүртгэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхий нийтээр тархаад байгаа шинэ төрлийн Коронавирус (COVID-19)-ийн халдвараас сэргийлэхэд зориулан иргэд, аж ахуй нэгж байгууллагаас хандив тусламжаар өгч буй мөнгөн тусламжийг нэмэлт санхүүжилтийн дансанд тушаах, бараа материалын хандив тусламжийг нягтлан бодох бүртгэлийн дагуу орлогод тусгаж, тухай бүр нь тушаал гаргаж зарцуулсугай

2. Тусламжаар ирүүлсэн мөнгөн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагын талаар шилэн данс, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт мэдээлж, зохих журмын дагуу тайланг гаргаж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (М.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Санхүү, хөрөнгө оруулалт, дотоод аудит хариуцсан нягтлан бодогч (Х.Амаржаргал)-д даалгасугай.

ДАРГА



М. ҮҮРИЙНБАЯР